

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 07 дугаар сарын 01-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-16
1. Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайлан	6-13
2. “Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	13-14
3. “Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	14-16

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
07 дугаар сарын 01-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Жавхлан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 35 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан;

Чөлөөтэй: Ц.Даваасүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Лодойсамбуу;

Тасалсан: Б.Батбаатар, Б.Чойжилсүрэн.

Нэг.Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Д.Гүн-үйлс, Ч.Батцэнгэл, Д.Мягмарсүрэн, Д.Наранцэцэг, С.Од-Эрдэнэ, М.Төрманлай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, референт О.Мөнгөнчавхдас, Б.Баясах нар байлцав.

Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайланг сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийн тавьсан асуултад нэр дэвшигч Д.Гүн-үйлс, Ч.Батцэнгэл, Д.Мягмарсүрэн, Д.Наранцэцэг, С.Од-Эрдэнэ, М.Төрманлай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр үг хэлэв.

Б.Жавхлан: 1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлсэн Дугарсүрэнгийн Гүн-Үйлсийг Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 8

Бүгд: 26

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Засгийн газраас нэр дэвшүүлсэн Чулуунбаатарын Батцэнгэлийг Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 17
Бүгд: 26
34.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Монгол Улсын Их Хурлаас нэр дэвшүүлсэн Дашзэвэгийн Мягмарсүрэнг Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 9
Бүгд: 26
65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын Их Хурлаас нэр дэвшүүлсэн Сандагийн Од-Эрдэнийг Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 7
Бүгд: 26
73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Монгол Улсын Их Хурлаас нэр дэвшүүлсэн Маналжавын Төрманлайг Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 12
Бүгд: 26
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Монгол Улсын Их Хурлаас нэр дэвшүүлсэн Дагвадоржийн Наранцэцэгийг Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 13
Бүгд: 26
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Б.Жавхлан: Нэр дэвшигчид дэмжигдсэнтэй холбогдуулан Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь дууссан Дэмбэрэлийн Өлзийбаатар, Сүхбаатарын Алтанцэцэг, Ванжилын Бат-Эрдэнэ, Доржсүрэнгийн Батсүх, Наваанпэрэнлэйн Жанцан нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 8
Бүгд: 26
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, референт О.Мөнгөнчавхдас, Б.Баясах нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Жавхлан танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Жавхлан: “Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	20
Татгалзсан:	6
Бүгд:	26

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, референт О.Мөнгөнчавхдас, Б.Баясах нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Жавхлан танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлэв.

Б.Жавхлан: “Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 6
Бүгд: 26
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 41 минут үргэлжилж, 32 гишүүнээс 26 гишүүн хүрэлцэн ирж, 81.3 хувийн ирцтэйгээр 14 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.ЖАВХЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 07 дугаар сарын 01-ний өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан эхлэхэд бэлэн боллоо.

Байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг та бүхэнд танилцуулъя.

Оюунсайханы Алтангэрэл гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Тогмидын Доржханд гишүүн, Бадрахын Найдалаа гишүүн, Бадарчийн Хэрлэн гишүүн, Доржзодовын Энхтуяа гишүүн, Аюушийн Ариунзаяа гишүүн, Баярмагнайн Баярбаатар гишүүн, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн, Болдын Жавхлан гишүүн, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн, Одонгийн Цогтгэрэл гишүүн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Лувсаннъямын Гантөмөр гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүд өнөөдрийн Байнгын хорооны хуралдааныхаа ирцэд бүртгүүлсэн байна. Ингээд 32 гишүүдээс 19 гишүүний буюу 59,4 хувьтайгаар ирц бүрдсэн байна. Гишүүд танхимдаа ирж хуралдаа оролцоно уу. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 3 асуудал байгаа.

1 дүгээрт Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсгол тайлан

2.“Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

3.“Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу. Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орно.

Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн сонсголын тайланг хэлэлцэж эхэлнэ.

Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг сонсгол даргалагч Сархадын Зулпхар гишүүн танилцуулна. Гишүүний микрофоныг нээж өгье.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийсэн нэр дэвшигчийн сонсголыг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэгт “Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар түүх уламжлал, ёс заншил, соёл, урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид, эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Улсын Их Хуралд, эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага, менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн газар тус тус санал болгоно.” гэж, 21.7 дахь хэсэгт “төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж, 21.8 дахь хэсэгт “нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийсний үндсэн дээр хэлэлцэж, Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилно.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан нэр дэвшигчийн сонсголыг үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлсэн Дугарсүрэн овогтой Гүн-Үйлс төрт ёс хаадын сан ТББ, Монгол Улсын Засгийн газраас нэр дэвшүүлсэн Чулуунбаатар овогтой Батцэнгэл МҮХАҮТ, Улсын Их Хурлаас нэр дэвшүүлсэн Эрдэнэбилэг овогтой Адьяасүрэн Тэтгэврийн реформ хөдөлгөөн нийтэд үйлчлэх ТББ, Жанчивдорж овогтой Билэгсайхан Монголын гольфийн холбоо нийтэд үйлчлэх ТББ, Дашзэвэг овогтой Мягмарсүрэн Монголын олон нийтийн харилцааны мэргэжлийн холбоо гишүүдэд үйлчлэх ТББ, Дагвадорж овогтой Наранцэцэг МҮЭХ, Сандаг овогтой Од-Эрдэнэ Соёл, спорт, боловсролын хөтөч нийтэд үйлчлэх ТББ, Маналжав овогтой Төрманлай Нийгмийн хөгжлийн гарц нийтэд үйлчлэх ТББ, Гүнчин-Иш овогтой Энхбаяр Монголын багш нарын холбоо нийтэд үйлчлэх ТББ, Лун овогтой Энхжин Монгол гайхамшиг төв нийтэд үйлчлэх ТББ, Батболд овогтой Энэрэлт Монголын боловсролын реформ хөдөлгөөн нийтэд үйлчлэх ТББ нар нь Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.

Монгол Улсын Их Хурлаас нэр дэвшүүлсэн 9 нэр дэвшигчийн 1 болох Эрдэнэбилэгийн Адьяасүрэн нь олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшихээс татгалзаж, нэрээ татах тухай хүсэлтээ ирүүлсэн.

2.2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хороо олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай тогтоолыг баталж, нэр дэвшигчийн сонсголыг 2026 оны 06 сарын 22-ны өдөр зохион байгуулахаар товлон, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхарыг томилсон.

Нэр дэвшигчийн сонсголыг 2026 оны 06 сарын 22-ны өдөр зохион байгуулахаар товлосон боловч Байнгын хорооны хуралдааны ирц бүрдээгүйн

улмаас хойшлогдсон тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор нэр дэвшигчийн сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулахаар дахин товлож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхарыг хэвээр томилсон.

3. Сонсголын бэлтгэл хангах хүрээнд.

Нэр дэвшигчийн мэдээллийг Parliament.mn буюу Улсын Их Хурлын цахим хуудсанд байршуулсан. Сонсголын тов хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудас бүхий зарыг Улсын Их Хурлын цахим хуудсанд 14 хоногийн хугацаанд байршуулсан. Мэдээллийн дагуу 2 оролцогч бүртгүүлснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар бүртгэж, баталгаажуулсан.

4. 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 14 цаг 25 минутад Төрийн байгуулалтын байнгын хорооны сонсголд Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, О.Алтангэрэл, А.Ариунзаяа, Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Ж.Баярмаа, Э.Болормаа, С.Бямбацогт, А.Ганбаатар, Ц.Даваасүрэн, С.Зулпхар, Л.Мөнхбаатар, Б.Найдалаа, Н.Номтойбаяр, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Ч.Ундрал, Н.Учрал, Б.Хэрлэн, Ө.Шижир, Б.Энхбаяр, Д.Энхтуяа нар буюу Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр ирц бүрдэж, нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргана.

Тайланд сонсголын дүнд үндэслэн гаргасан нэр дэвшигчийн тухайн албан тушаалд тавих шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгаж холбогдох бусад мэдээллийг хавсаргана гэж заасны дагуу 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.

Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүдийн хаалттай хуралдаж Монгол Улсын Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлсэн Дугарсүрэнгийн Гүн-Үйлс, Улсын Их Хурлаас боловсролын чиглэлээр нэр дэвшүүлсэн Дашзэвэгийн Мягмарсүрэн, Маналжавын Төмөрманлай, Биеийн тамир спортын чиглэлээр нэр дэвшүүлсэн Сандагийн Од-Эрдэнэ, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр нэр дэвшүүлсэн Дагвадоржийн Наранцэцэг нарыг ажлын хэсгийн тайлан, ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас нэр дэвшүүлсэн Чулуунбаатарын Батцэнгэл, Улсын Их Хурлаас боловсролын чиглэлээр нэр дэвшүүлсэн Гүнчин-Ишийн Энхбаяр, Лунаагийн Энхжин, Батболдын Энэрэлт, Биеийн тамир, спортын чиглэлээр нэр дэвшүүлсэн Жанчивдоржийн Билигсайхан нарын ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг хангаагүй гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд санал болгосон нэр дэвшигчийн талаарх сонсголын тайланг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Жавхлан: Зулпхар гишүүнд, хурал даргалагчид баярлалаа. Нэр дэвшигч Дугарсүрэнгийн Гүн-Үйлс, Чулуунбаатарын Батцэнгэл, Дашзэвэгийн Мягмарсүрэн, Дагвадоржийн Наранцэцэг, Сандагийн Од-Эрдэнэ, Маналжавын Төрманлай нарын танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа.

Нэр дэвшигчийн сонсголын тайлан болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Алга байна. Гантөмөр гишүүнээр тасаллаа. Гантөмөр гишүүний нэр орсон байна. Микрофоныг нээж өгнө үү.

Л.Гантөмөр: Өдрийн мэнд хүргэе. Үндэсний радио, телевизийг бид нар бие даалгах гэж их олон жилийн өмнө хуулийг нь өөрчилсөн. Тэгээд удирдах зөвлөл та бүхнээр дамжуулаад уг нь бие даалгах гээд оролдоод байгаа юм. Харамсалтай нь ерөөсөө бие даахгүй байна. МАН-ын суртал, ухуулгын хэлтэс хэвээрээ байгаад байна. Засгийн газрыг магтан дуулдаг хэвээрээ байгаад байна. Ялангуяа та бүхэн бол үндэсний телевизийг хардаг бол мэдээ мэдээлэл дотор жишээлбэл ордны баруун, зүүн гар талд байгаа жагсаалын тухай мэдээ гарч байна уу. Хэрвээ өөр улсад бол үндэсний мэдээ мэдээллийн сувгаар энэ тухай бараг өдөр болгон ярих ёстой. Чуулган нээгдэхэд энэ хүмүүс жагсаж эхэлсэн. Чуулган одоо хааж байна. 1 ч асуудлыг нь шийдээгүй. Гэтэл энийг үндэсний телевиз гаргадаггүй. Аль нэг сайд нь хөдөө хүмүүстэй уулзахаар явахаар тэр хүний тухай өдөр болгон шахуу гаргадаг. Бүр яг Засгийн газрын гар хөл болсон. Тэгэхээр та бүхэн 1 зүйлд хариулт өгөөч. Яаж энэ Засгийн газрын гар хөл болж байгааг та нар салгах юм бэ. Салгаж чадах уу. Салгах итгэл үнэмшил байна уу. Томилсон ноёдынхоо боол болчихгүй юм биш биз дээ. Намайг Ерөнхийлөгч томилж байгаа, намайг Их Хурлын дарга томилж байгаа, намайг Засаг оруулж байгаа ч гэдэг юм уу. Тоглоом биш шүү. Бидэнд одоо байгаа хамгийн боломжит хэвлэл мэдээллийн монголчуудад зориулагдсан хэрэгсэл бол Үндэсний олон нийтийн телевиз. Бусад телевизүүдийг нь энэ том олигархууд бүгдийг нь авчихсан. Намын дарга нь хүртэл телевизтэй болчихсон. Ерөнхий сайд хүртэл өөрийн телевизтэй. Ийм улс байгаад байгаа байхгүй юу. Малчин гэдэг телевизтэй, Роял гэдэг телевизтэй. Малчин телевизээр өдөр болгон Засгийн газрыг магтан дуулдаг. Ийм болчихсон. Тэгэхээр та бүхэн бол энэ бие даалгана гэдэг итгэл үнэмшлийг ний нуугүй яримаар байна. Би бол аль нэг намын тухай яриад байгаа хэрэг биш. Яаж бие дааж явах юм бэ. Яаж танай сэтгүүлчид хэвлэн нийтлэх эрх чөлөөгөөр хангагдах юм бэ.

Б.Жавхлан: Нэр дэвшигчид 5 номероос эхлээд өөрийгөө товчхон танилцуулаад, нэг их айхтар намтраа уншаад хэрэггүй шүү. Овог, нэрээ танилцуулаад, асуултад хариулаад явна. 5 номер.

С.Од-Эрдэнэ: Энэ өдрийн мэндийг та бүхэнд дэвшүүлье. Миний бие Сандагийн Од-Эрдэнэ байна. Тэгээд юуны өмнө МҮОНРТ бол бас олон нийтэд үйлчилдэг хараат бус байх ёстой. Энэ зарчим бол хамгийн чухал байгаа. Тийм ч учраас миний бие Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа зорилгын хамгийн гол агуулга бол саяын энэ хараат бус байх, 1 намын биш, иргэд, олон нийтийн телевиз байхын төлөө бол ажиллана. Юуны өмнө редакцын хараат бус байдлыг хамгаалах ажилд иргэд үнэн зөв, тэнцвэртэй

мэдээлэл авах талаас нь бол дуу хоолой болж ажиллах ийм зорилгыг бол агуулж байгаа.

Б.Жавхлан: 6 номер.

Д.Гүн-Үйлс: Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Энэ бол маш чухал асуудал хөндөж байна.

Б.Жавхлан: Овог, нэр байна уу.

Д.Гүн-Үйлс: Уучлаарай. Дугарсүрэнгийн Гүн-Үйлс. Тэгэхээр яг л тэр сонгодог утгаараа олон нийтийн радио, телевиз ямар байх ёстой вэ. Яг л тэгж л ажиллуулахыг би хүсэж, зөвлөж, тэгж ажиллана гэж бодож байна. Шахаж ажиллана гэж бодож байна. Мэдээж хэрэг ард түмний телевиз, олон нийтийн телевиз гэдэг бол аль 1 намд, аль 1 Засгийн газарт тал өгч болохгүй. Ер нь хамгийн гол нь л ард түмнийг соён гэгээрүүлэх тал дээр түлхүү ажиллах ёстой. Мэдээж хэрэг цаг үеийн мэдээ мэдээллийг бол шуурхай дамжуулах ёстой. Гишүүний хэлсэнчлэн яг улс оронд болж байгаа тэр жагсаал цуглаан, хэрвээ тэд нарын .../минут дуусав/

Б.Жавхлан: Нэр дэвшигчид минутдаа багтаана шүү.1 минут. Дараагийнх 7 номер.

Д.Мягмарсүрэн: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Дашзэвэгийн Мягмарсүрэн байна. Үндэсний радио, телевизийн хуульд Үндэсний зөвлөл бол олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байдаг. Тэгэхээр мэдээллийн тэнцвэрт байдлыг хангах тал дээр олгогдсон эрх, үүргийн хүрээнд ажиллана. Баярлалаа.

Б.Жавхлан: 8 номер.

Ч.Батцэнгэл: Өдрийн мэнд хүргэе. Чулуунбаатарын Батцэнгэл байна. Олон нийтийн радио, телевизийн хараат бус байдлыг хангахад юун түрүүн төсөв ярих хэрэгтэй болдог. Мөн хураамжийн асуудал, хураамж гэдэг нь үйлчилгээний хөлсийг нэмэх тухай асуудал байдаг. Энэ үйлчилгээний хөлсийг хамгийн анх 1998 онд Засгийн газрын тогтоолоор тухайн үеийн 1 доллартой харьцуулаад 1100 төгрөгөөр тогтоосон байдаг. Түүнээс хойш бол огт хөдлөөгүй, өөрчлөгдөөгүй явж байгаа. Төсөв дээр бол бас хүнд байдаг. Адилхан төсвийн байгууллагуудтай адилхан явдаг. Ер нь бол энэ хараат бус байдлаас хамгийн хурдан гарах арга зам бол энэ үйлчилгээний хураамжийг бас тодорхой хувиар нэмээд, хуульд бас тодорхой заалтууд, өөрчлөлтүүд оруулах ёстой гэж ингэж бодож байгаа. Баярлалаа.

Б.Жавхлан: Дараагийн нэр дэвшигч. 9 номер.

Д.Наранцэцэг: Сайн байцгаана уу. Би Дагвадоржийн Наранцэцэг байна. Сая бол бас их мундаг ийм хэрэгцээтэй асуулт. Энийг бол бас ярьж гэж бодож байсан. Тэгэхээр Олон нийтийн радио, телевизийн хуулийн 1 дүгээр зүйлийн 7 дугаар бүлэг дээр төрөөс дэмжлэг авах гэж байгаа юм. Ер нь бол анх 2005 онд энэ хуулийг батлахдаа төрийн дэмжлэгийг бага болгоод, редакцын хараат бус байдлыг нэлээн сайн сайжруулна гэсэн ийм байдалтай байсан болов манай олон нийтийн радио, телевизийг анх хуулийг нь батлаад гаргахдаа техник, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалт нь өөр юманд зарцуулагдаад байдаг. Тэгэхээр гол юм нь бол сая Батцэнгэл даргын ярьж байгаа шиг 1 дүгээрт нь хураамжаа нэмэх, 2 дугаарт нь төсвийн орж ирж байгаа төрөөс орж ирж байгаа юуг тогтвортой болгох гэдэг ийм

санал байвал их зүгээр санагддаг. Урагшаа, хойшоо хөдлөөд, дээшээ, доошоо болоод, захирлаасаа хамаараад мөнгө нь саваад байхаар энд бас улс төрийн хараат байдал ороод байдаг. Захирлууд маань үг дуугүй тэрэнд захирагдаад байдаг юм байна гэсэн тийм бодол бол энэ он жилүүддээ төрсөн байгаа. Тэгэхээр төсвийн дэмжлэгийг тогтвортой байлгах нь хараат бус байлгах.../минут дуусав/

Б.Жавхлан: Хамт юм байна шүү. Гишүүн тодруулъя. Гантөмөр гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Л.Гантөмөр: Төсөв хүрэлцэхгүй байгаа байдлыг бол ойлгож байгаа. Тэгэхдээ гол нь Удирдах зөвлөлд орж байгаа энэ байгууллагыг удирдах хүмүүсийн сэтгэл зүрх хамгийн чухал шүү гэдгийг хатуу анхааруулж хэлье. Ер нь бол дарга нарт тал засаж байж, дарга нарын мэдээллийг тавьж байж тэгээд хэдэн төгрөг олж авч амьдарна гэдэг бол угаасаа болохгүй шүү. Харин байгаа мөнгөндөө нуруутай байх шаардлагатай гэж ингэж харагдаж байгаа юм. Ер нь бол бид нар Монгол Улсын хэвлэл мэдээллийг улс төрчдөөс чөлөөлөх ажлыг Ерөнхий сайдын чөлөөлье санаачилгын хүрээнд заавал хийнэ. Энэ намартаа багтаагаад улс төрчид болоод, тэдний хамаарал бүхий этгээдүүдээс Монгол Улсын хэвлэл мэдээллийн салбарыг салгах чөлөөлөх ажил бол явагдана. Тэгээд энэ хүрээнд та бүхэн харин эсрэгээрээ баригдаад явчхав гэдгийг хатуу сануулж хэлж байна. Баярлалаа.

Б.Жавхлан: Гантөмөр гишүүн асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт гишүүд нууц санал хураалт явуулахаар заасан байдаг. Иймд Байнгын хороон дээр мөн нууц санал хураалтыг цахимаар явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Харин тийм. Чуулган завсарлах гээд бас нэлээн ачаалалтай энэ 7 хоног явж байгаа. Зарим Байнгын хороодын хурал, ажлын хэсгийн хурлууд давхардаад байгаа учраас гишүүд бас зэрэг зэрэг ирцэд орох шаардлагууд байгаад байгаа. Сая 2, 3 ч гишүүн гараад явчихлаа. Нөгөө Байнгын хороон дээр ирцэд орох гээд. Чуулганы ирцдээ би ч ороогүй явж байгаа шүү. Чуулганы ирцдээ би ч ороогүй байна даа. Хүлээх үү. Нэр дэвшигч чинь байхгүй байх юм. Маналжавын Төрманлай нэр дэвшигч байхгүй байна.

Энэ хаврын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны хамгийн ирц өндөртэй хуралдаан болж байна шүү. Гишүүд ийм өндөр ач холбогдол өгч, хуралдаанд, асуудалд хандаж байхад нэр дэвшигч нар өөрсдөө байхгүй байх юм. Ямар учиртай юм бэ. Ямар шалтгаантай ирээгүй байгаа юм. Үгүй ээ, бүгдээрээ л адилхан шүү дээ. Бүгдээрээ л адилхан нэр дэвшигч. Дуудаарай.

Гишүүд ээ, анхааралтай байгаарай. Ирцийн бүртгэл хийгээд үзье. Бүртгэлийн санал хураалт. Бүртгэлийн санал хураалт шүү. Байгаа л байна. Болж л байна даа. Мөнхбаатар гишүүн ороод ирлээ. Тэгвэл ирц хураагаад явъя даа. 25 гишүүн ирцэд орсон. 18 гишүүн санал хураалтдаа оролцохоор бэлэн болсон байна. Номтойбаяр гишүүн орчхоорой Номтойбаяр гишүүн, Мөнхбаатар дарга ирцэд бэлэн болчихоорой. Төхөөрөмжөө уншуулаад. Тийм бэлэн болсон байна. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлсэн Дугарсүрэн овогтой Гүн-Үйлсийг Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалт 69,2 хувиар дэмжигдлээ.

2.Засгийн газраас нэр дэвшүүлсэн Чулуунбаатар овогтой Батцэнгэлийг Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 26 гишүүд оролцож, 34,6 хувиар дэмжигдэж, санал хураалт дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлаас нэр дэвшүүлсэн Дашзэвэг овогтой Мягмарсүрэнг Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 26 гишүүн оролцож, 17 гишүүн дэмжиж, 65,4 хувиар санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлаас нэр дэвшүүлсэн Сандаг овогтой Од-Эрдэнийг Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 26 оролцож 19 гишүүн дэмжиж, 73,1 хувиар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлаас нэр дэвшүүлсэн Маналжав овогтой Төрманлайг Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 26 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 53,8 хувиар дэмжигдлээ.

Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлд ажиллаж байгаа, өмнө нь Улсын Их Хурлаас нэр дэвшиж ажиллаж байгаа хугацаа нь ингээд 4 сарын 19-нд зэрэг дуусаж байгаа юм байна шүү дээ. 3 хүн зэрэг дуусаад, энэ 3 орон тоон дээр Улсын Их Хурлаас дэвшүүлсэн 3 хүн дэмжигдлээ.

Тийм учраас 4 дэх санал хураалт явуулах шаардлагагүй.

Дэгийн тухай хуулийн 39.20-ыг уншиж танилцуулъя. Анхааралтай сонсоорой. Тайван сонсох хэрэгтэй шүү.

39.20.Төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын томьёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж, санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй. Энэ хуулийн 39.9-д заасны дагуу ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна. Энэ нь өөрөө хамааралтай ийм юмаар явлаа шүү. Тэгэхдээ санал хураалт бол яг энүүгээр явж байна шүү. Үгүй ээ, үгүй. Одоо энэ чинь хардаа. 3 хүний л квот байгаа шүү дээ 3 хүний л квот. Гишүүд анхааралтай байгаарай.

6.Улсын Их Хурлаас нэр дэвшүүлсэн Дагвадоржийн Наранцэцэгийг Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 26 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 50 хувийн санал авч, санал дэмжигдсэнгүй.

Нэр дэвшигчид дэмжигдсэнтэй холбогдуулан Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь дууссан Дэмбэрэлийн Өлзийбаатар, Сүхбаатарын Алтанцэцэг, Ванжилын Бат-Эрдэнэ, Доржсүрэнгийн Батсүх, Наваанпэрэнлэйн Жанцан нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх нь зүйтэй гэж үзсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 26 гишүүн оролцож, 18

гишүүн дэмжиж, 69,2 хувиар уг санал дэмжигдэж, нэр дурдсан өмнөх гишүүдийг чөлөөллөө.

Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар танилцуулна.

14.07 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлнэ.

Энэ хаврын хамгийн өндөр ирцтэй хуралдаан болж байна шүү. Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа. Энэ тогтоолыг нь унших юм уу. Тараачихсан юм байна. Унших хэрэг байна уу. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт “Байнгын, дэд хороо дараагийн ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгуулах саналаа ээлжит чуулган завсарлахаас ажлын 10 өдрийн өмнө Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.” гэж, мөн зүйлийн 8.6 дахь хэсэгт “Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварыг холбогдох шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт 8 Байнгын хороо, 1 дэд хороо саналаа ирүүлсэн бөгөөд тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх хүрээнд 16 санал хяналт шалгалтын бусад асуудлын хүрээнд ерөнхий хяналтын сонсгол 2, нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах 1 санал, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах ажлын хүрээнд 3 санал, хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлын хүрээнд 3 санал тус тус ирүүлж, нийт 25 төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр цаглаварын хавсралтад тусгах саналтай байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг та бүхэнд уншиж танилцууллаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд анхааралтай байгаарай.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн

томьёоллоор санал хураая. Санал хураалт. Санал хураалтад 26 гишүүн оролцож, 20 гишүүн дэмжиж, 76,9 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн гараа өргөснөөр нь л явна шүү. Ариунзаяа гишүүн гараа өргөлөө. Энэ хаврын чуулганы хамгийн их өөрөө санаачилгаараа танилцуулан уншиж байгаа Ариунзаяа гишүүн шалгарч байгаа шүү. Тэр нь шударга биз дээ. Гараа өргөснөөс нь эхэлж явна.

“Монгол Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

14.11 цаг.

Хэдүүлээ гялалзуулчихъя. Одоо ганцхан асуудал. 5 минут.

Дараагийн асуудалдаа оръё.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлнэ.

Танилцуулга уншина.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.1-д “Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг оруулна.” гэж заасан тул дараах хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг тусгалаа.

1/Батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан хууль тогтоолын төсөл

1.Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төсөл

2.Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2026 оны гүйцэтгэл, 2027 оны төсвийн тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

3.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2027 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

4.”Улсын Их Хурлын 2027 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай болон ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хянан шалгалтын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд.

2/Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлгийн шатанд байгаа 80 хуулийн төсөл, 8 Улсын Их Хурлын тогтоолын төсөл байна. Эдгээрээс Их Хуралд

өргөн мэдүүлсэн бөгөөд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулаагүй байгаа 23 хуулийн төсөл, 1 Улсын Их Хурлын тогтоолын төслийг тусгахаар бэлтгэлээ.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай тогтоолын төсөлд нийт 24 хуулийн төсөл, 5 тогтоолын төсөл, нийт 29 төсөл тусгалаа.

3/Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулаагүй байгаа хууль, тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн дарааллаар жагсаасан болно.

4/Хэлэлцүүлгийн шатад байгаа хууль, тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэх, уг тогтоолын 1 дүгээр заалтад зааснаас бусад хууль, тогтоолын төслийн Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх эсэх асуудлыг тухай бүрд нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д заасны дагуу шийдвэрлэхээр төсөлд тусгасан болно.

Та бүхэнд танилцуулга уншиж, танилцууллаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Гишүүд санал хураалтад бэлдье. Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуулт асууж, үг хэлэх нь. Гишүүний микрофоныг нээе.

О.Алтангэрэл: 2026 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх энэ асуудлын тухай тогтоолыг дэмжиж байна. Тэгээд 1 зүйлийг би зориуд онцолж хэлэх гэсэн юм. Монгол Улсын Засгийн газраас Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжилж нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл болон бусад хуулийн төслүүдийг өргөн мэдүүлээд, өнөөдөр 405 хонож байна. Өнөөдөр яг 405 хонож байгаа юм. Тэгээд 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр манай Амарбаясгалан дарга сууж байна. Амарбаясгалан даргын үед өргөн барьсан. Дараа нь Учрал дарга Улсын Их Хурлын дарга байхдаа хэлэлцье гэсэн. Дараа нь Засгийн газраас сая Бямбацогт даргын үед Засгийн газраас өөрсдөө төсөл дээрээ ажиллая, дахиад сайжруулж өргөн барья гэж хэлээд, энэ чуулганы хугацаа ингээд дууслаа. Тэгээд 3 удаа ингэж хэлэлцэх асуудлын дараалалд орж байна. Энэ асуудал. 3-ын 3 удаа. Одоо яг энэ хэлэлцэх асуудлын дарааллын 7-д нь энэ хуулийн төсөл орчхоод ингээд л батлаад л сууж байна. Тэгээд үнэхээр 2 чуулганы хугацаанд бол тэсвэр тэвчээртэйгээр энийг хэлэлцэх болов уу гэж хүлээлээ. Ард иргэдийн зүгээс бол нэлээн хүлээлттэй байгаа. Тэгэхээр үнэхээр Монгол Улсын Засгийн газар дахиад шинэчлээд, энэ дээрээ бас дахиж өргөн барья, засаж сайжруулах зүйл байна гэвэл энэ асуудлаа хурдалмаар байна.

Тэгээд Монгол Улсын Их Хурлын зүгээс энэ хуулийг хэлэлцэн батлахыг бол ард иргэдээс шаардаж байгаа юм. Тэгээд маш хүлээцтэйгээр, маш тэвчээртэйгээр хоног тоолон ингэж хүлээлээ. Одоо намрын чуулган эхэлнэ. Ер нь бол энэ тэвчээрийн утас бол тасрах нь ээ. Дуусаж байна. Дахиж ингээд хүлээцтэйгээр, яах нь вэ гээд царайчлаад ингээд байж чадахгүй. Ер нь улс орны энэ авлигын нөхцөл байдалтай тэмцэх, авлигын индексээ бууруулах, энэ авлигачин хулгайчуудтайгаа тэмцэх ажлыг хууль тогтоомж, хэм хэмжээгээр хийнэ үү гэхээс биш уриа лоозонгоор хийхгүй. Энэ дээр Улсын Их Хурал онцгой анхаарал хандуулах ёстой. Тийм учраас энэ удаагийн Улсын Их Хурлын тогтоолоор Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын 7-д яг энэ Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө хураах тухай хуулийн төсөл багтлаа. Тэгэхээр энэ учраас бид нар намар энэ асуудлаа багтааж хэлэлцэж шийдвэр гаргах ёстой шүү гэдгийг бас

онцолж хэлье. Засгийн газрыг бас асуудлаа түргэлээч гэдэг асуудлыг хэлье. Баярлалаа.

Б.Жавхлан: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд бэлэн болсон байна.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томьёолоор санал хурааа. Санал хураалт. Санал хураалтад 26 гишүүн оролцож, 20 гишүүн дэмжиж, 76,9 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх хүртэлх хугацаанд шинээр өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг энэ тогтоолын төсөлд нэмж тусгах шаардлагатайг протоколд үлдээе.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар танилцуулна. Түрүүлж гар өргөсөн.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Хаврын чуулганы хамгийн ирц өндөртэй, Төрийн байгуулалтын байнгын хороонд идэвхтэй оролцсон нийт гишүүддээ талархлаа.

Хуралдаан хаасныг мэдэгдье. Маргааш өглөө 9 цагаас Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдана. Гишүүд өнөөдрийнхөө ирцээр маргааш идэвхтэй оролцохыг хүсэж байна.

14.16 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ